



Г ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАНДАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2018.05.28 № 05/4541
танай 2018.05.27 ны № 01/1738 -т

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Татварын ерөнхий газрын Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Дүгэrsүрэнгийн Батжаргал, Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн Татварын орлогын тасгийн дарга, татварын улсын ахлах байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Гунгаагийн Сүрэнтамжид, Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн Татварын орлогын тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Цагааны Цэнгэл, Татварын ерөнхий газрын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэст Ерөнхий санхүүчээр томилогдохоор нэр дэвшсэн Баатарын Саруултэгс, Баянгол дүүргийн татварын хэлтсийн Татварын орлогын тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Дамбийжаагийн Энхбаяр нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.


Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Харин Татварын ерөнхий газрын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн Ерөнхий санхүүчийн ажлын байрны тодорхойлолтын ерөнхий шаардлагад төрийн албанад 5-аас доошгүй жил гүйцэтгэх албан тушаал эрхэлсэн байхаар заасныг нэр дэвшигч Б.Саруултэгс нь хангаагүй байна.

Иймд тус албан тушаалд холбогдох хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагад нийцсэн этгээдийг нэр дэвшүүлэн томилохыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

X.ХАШБААТАР



007907